



**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

2012-2015 он

2015 он



ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2012-2015 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Эмхтгэсэн: О.Батчимэг
Хянасан: „„„„„
Боловсруулсан: Аймгийн ИТХ
Эхийг бэлтгэсэн: Ч.Болормаа

Цаасны хэмжээ: 70x100 $\frac{1}{16}$ B5 (176x250)
Бодит хэвлэлийн хуудас: 10,64 х.х
Тооцооны хэвлэлийн хуудас: 8,25 х.х
“Линограф” хэвлэлийн үйлдвэрт хэвлэв.



МЭНДЧИЛГЭЭ

Хөдөлмөрийн гавъяаны улаан тугийн одонт говь нутгийн хөдөлмөрч хичээнгүй ард иргэд Та бүхэнд Өмнөговь аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Төлөөлөгчид, Тэргүүлэгчдийн өмнөөс чин сэтгэлийн халуун мэндчилгээ дэвшүүлье.

Монгол Улсын 1992 оны ардчилсан, шинэ Үндсэн хуулийн дөрөвдүгээр бүлэг, тавин есдүгээр зүйлд заасны хүрээнд Нутгийн өөрөө удирдах байгууллагын зургаа дахь удаагийн сонгуулийн үр дүнд байгуулагдсан аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал нь Өмнөговь аймгийн иргэдийг оюунлаг, төлөвшсөн, чинээлэг амьдралтай байлгах, аюулгүй цэвэр, эрүүл, орчинд амьдарч ажиллах нөхцлийг бүрдүүлэх, дэд бүтэц, аялал жуулчлал, уул уурхайн үйлдвэрлэл болон бүсчилсэн хөгжлийн бодлогод тулгуурлан аймгийн нийгэм, эдийн засгийн тулгамдсан асуудлуудыг ард иргэдийн идэвхтэй оролцоонд түшиглэн нөөц боломжоо дайчлан шийдвэрлэх, төрийн ба төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн аж ахуйн нэгжийн хамтын оролцоотойгоор орон нутгийн дэвшилтэт хөгжлийг хангах зорилго дэвшүүлсэн билээ.

Зорилгын хүрээнд аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаас 2012-2016 онд баримтлах таван үндсэн зорилттой үзэл баримтлалыг батлаж, Өмнөговь аймгийн нийгмийн хөгжлийн тэргүүлэх салбар “Боловсрол”, эдийн засгийн хөгжлийн тэргүүлэх салбар “Уул уурхай” гэж тодорхойлон түүнийгээ хэрэгжүүлэн ажиллаж байна.



Өмнөговь аймаг боловсролын салбарт олон улсын хэмжээнд өрсөлдөхүйц соёл, боловсролтой иргэнийг төлөвшүүлэх зорилгыг дэвшүүлэн энэхүү зорилгодоо хүрэхийн тулд боловсролын харилцаанд оролцогчдын хандлагыг өөрчлөх замаар багш, хүүхэд бүрийг хөгжүүлж, боловсролын үйлчилгээний чанарыг шинэ түвшинд хүргэх, эх оронч, бүтээлч, өрсөлдөх өндөр чадвар бүхий боловсролтой “Зөв Монгол хүн”-ийг төлөвшүүлэх олон талт нөхцөл боломжийг бүрдүүлэн өнгөрсөн 3 жилийн хугацаанд боловсролын салбарт орон нутгийн төсвөөс 18,5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийлээ.

Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төвөөс Монгол Улсын өрсөлдөх чадварын судалгааны аргачлалын дагуу аймаг бүрийн тулгамдаж буй бэрхшээлийг зохистой шийдвэрлэж, байгаа боломжийг ашиглан өрсөлдөх чадварыг нь бүрдүүлэх зорилгоор 21 аймгийн хөгжлийн өрсөлдөх чадварын судалгааг 180 үзүүлэлтээр шинжилэн, өрсөлдөх чадварын ерөнхий үнэлгээгээр манай аймаг Орхон аймгийн дараа хоёрт эрэмбэлэгдсэн үзүүлэлт нь байгалийн баялагийн зүй зохистой ашиглалт оновчтой бодлого үйл ажиллагааны үр шим говь нутгийн ард түмний хөдөлмөрийн үр дүн билээ.

Өмнөговь аймаг ашигт малтмалын салбараас орж ирж буй орлогоо зүй зохистой хуваарилаж, урт хугацааны тогтвортой хөгжлийн төлөө Орон нутгийн удирдлага, бизнес эрхлэгчид болон төрийн байгууллага хоорондын уялдаа холбоог сайжруулах, тулгамдаж буй асуудлуудаа бодитой тодорхойлон, орон нутагт шийдвэрлэж болох асуудлыг хамтран бодит ажил болгон ажиллаваас үр дүнд хүрдгийг харуулж байна.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаас Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төвтэй хамтран Өмнөговь аймгийн 15 сумын өрсөлдөх чадварын судалгааг гаргаж сум тус бүрийн өрсөлдөх чадварын түвшинг тогтоолоо. Сумдууд өрсөлдөх чадвараа өсгөн үр дүнтэй ажиллах боломж байна.

Хөдөө аж ахуйн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэл мал аж ахуй, газар тариаланг хослуулан хөгжүүлэх, хоршоодын үйл ажиллагааг идэвхижүүлэн дэмжиж, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх, байгаль орчны унаган төрх, гүний цэнгэг, ундны ус түүний ай савыг хамгаалах, экологийн тэнцвэрт байдлыг хадгалах, говийн байгалийн үзэсгэлэнт тогтоц бүхий газар нутаг, орон нутгийн онцлог шинжийг илтгэсэн брэнд бүтээгдэхүүнээр дамжуулан аялал жуулчлалыг хөгжүүлэх, хөрш зэргэлдээ орнуудын аялал жуулчлалын салбартай харилцан ашигтай хамтран ажиллах нь Өмнөговь аймгийн тогтвортой хөгжлийн үндсэн нөхцөл болж байгаа билээ.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, түүний Тэргүүлэгчдээс бүрэн эрхийн хугацаанд “Зөв Монгол хүүхэд”, “Соёл урлагын хөгжил”, “Авьяс”, “Биеийн тамир спортыг хөгжүүлэх цогц хөтөлбөр”, “Өрхийн эрүүл мэндийн



төвүүдийг хөгжүүлэх”, “Амьдралын буруу хэвшлээс үүдэлтэй өвчнөөс сэргийлэх, хянах дэд хөтөлбөр”, “Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нөхөн сэргээлт”, “Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн орчныг сайжруулах”, “Аймгийн 40-өөс дээш насны ажилд ороход хүндрэлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”, “Ажилтай орлоготой эмэгтэйчүүд” дэд хөтөлбөр, “Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих”, “Тонн баялаг-Нэг мод”, “Хүнс хөдөө аж ахуйн хөгжлийн хөтөлбөр”, “Архигүй Өмнөговь” зэрэг хөтөлбөр, журмуудыг баталж, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

Говь нутгийн хөгжил цэцэглэлтийн төлөө бодлого тодорхойлох үйлсэд Төлөөлөгчөөрөө дамжуулж болон шууд оролцож байгаа ард иргэд, төрийн захиргааны байгууллага, төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн салбарын хамт олон Та бүхэндээ аз жаргал амжилт бүтээлийг хүсэн ерөөе.

Энэхүү эмхэтгэлээр аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаас 2012-2015 онд хийсэн ажлаа тоймлон иргэд Та бүхэнд хүргэж байна.

Говь нутаг минь цэцэглэн хөгжих болтугай.

ХУРЛЫН ДАРГА



Л.БАТЧУЛУУН



ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2012-2015 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал/ИТХ/ нь 2012-2016 оны бүрэн эрхийн хугацаанд 33 Төлөөлөгч, 11 Тэргүүлэгчтэйгээр орон нутгийн нийгэм, эдийн засаг, дэд бүтцийг хөгжүүлэх, байгаль орчныг хамгаалах, нутгийн өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагааг төлөвшүүлэхэд удирдлага зохион байгуулалтын ажлаа чиглүүлэн ажиллалаа.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Төлөөлөгчид жилд дунджаар 2-3, Тэргүүлэгчид 18-21 удаа хуралдаж орон нутгийн нийгэм, эдийн засгийн тулгамдсан асуудлууд болон бодлогын чанартай асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэж байна.



Аймгийн ИТХ-ын хуралдаанаар хэлэлцсэн асуудал

Аймгийн ИТХ-ын Төлөөлөгчдийн хуралдаанаар жил бүрийн аймгийн нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэл, төсөв, төсвийн тодотгол, газар зохион байгуулалтын төлөвлөгөө, тэдгээрийн хэрэгжилтийг хэлэлцэж батлахаас гадна Гурвантэс сумын Баясах баг, Ноён сумын Толь хад, Ноён богд, Саран хөндий орчмын газрууд болон газрын доорх цэнгэг усны орд газрыг байгалийн унаган төрх, хэв шинжийг хадгалах, усны эх үүсвэрийг хамгаалах зорилгоор орон нутгийн тусгай хамгаалалтад авах, Уул уурхайн үйлдвэрлэлийн зориулалтаар газрын доорх гүний усыг ашиглахыг хориглох, ус хэрэглэгчдэд газрын доорх ус ашиглалтын цооног



өрөмдөх зөвшөөрөл олгох, ус ашиглагчтай гэрээ байгуулж, гэрээний хугацааг сунгах, рашаан ашиглах, савлах тэмдэгтийн хураамжийг тогтоох, Түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хэмжээ болон Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын хувь хэмжээ, олон нийтийн цагдаагийн ажилтны тоог тогтоох, мал эмнэлэг үржлийн ажил үйлчилгээний төлбөрийн жишиг үнэлгээг шинэчлэн батлах, төсвийн байгууллагын албан хаагчдад говийн нэмэгдэл олгох журмыг хүчингүй болгох, Даланзадгад сумыг улсын зэрэглэлтэй хот болгох асуудлыг Засгийн газарт уламжлах, “Монгол тэмээ-999” арга хэмжээг зохион байгуулах, Баянхонгор аймгийн Шинэжинст сумын Хотгорын уурхайгаас Өмнөговь аймгийн Гурвантэс сумын Шивээхүрэн хилийн боомт хүртэлх замын асуудал, аймгийн газар өмчлүүлэх ажлыг эрчимжүүлэх ажлын төлөвлөгөө зэрэг асуудлуудыг хэлэлцэж шийдвэрлэлээ.



Төлөөлөгчдийн хуралдаан



Тэргүүлэгчдийн хурал

Аймгийн ИТХ-ын хуралдаанаас гарсан шийдвэр

Дээрх хэлэлцсэн асуудлуудаас гарсан шийдвэрийн зарим хэсгийг тодруулан танилцуулбал аймгийн нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлд 2013 онд 97824,0 сая төгрөгний 278 ажил, 2014 онд 100077,9 сая төгрөгний 196 ажил, 2015 онд 123339,1 сая төгрөгний 218 ажил төлөвлөн, хэрэгжилтийг тооцон ажиллалаа.



Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2013 оны 31 дүгээр тогтоолоор Уул уурхайн болон бусад үйлдвэрлэл үйлчилгээний зориулалтаар ашиглаж буй усны ашиглалт, хамгаалалтад хяналт шалгалт хийх, дүгнэлт өгөх зорилгоор ажлын хэсэг байгуулан Гурвантэс, Ноён, Ханбогд, Цогтцэций сумдад ажилласан бөгөөд уул уурхайн компаниуд ус ашигласны төлбөрөө төлөөгүй, зарим газар усны тоолуурын баталгаат хугацаа дууссан, усыг зүй зохистой ашиглахгүй байгаа зэрэг зөрчил дутагдал илэрсэн тул аймгийн ИТХ-ын 2013 оны 07 дугаар сарын 02 өдрийн Төлөөлөгчдийн



хуралдаанаар уул уурхайн үйлдвэрлэлийн зориулалтаар газрын доорх гүний усыг ашиглуулахаар эрэл хайгуул хийх, цооног өрөмдөх зөвшөөрөл олгохыг 2013 оны 08 дугаар сарын 01-ээс уул уурхайн үйлдвэрлэлийн зориулалтаар газрын доорх гүний ус ашиглахыг 2016 оны 01 дүгээр сарын 01-ээс хориглох шийдвэр гаргасан боловч Засгийн газар болон уул уурхайн компаниудын эсэргүүцэлтэй тулгарч, тус шийдвэрээ 2013 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн Төлөөлөгчдийн хуралдаанаар хүчингүй болгосон.

Харин ус хэрэглэгчдэд газрын доорх ус ашиглалтын цооног өрөмдөх зөвшөөрөл олгох, ус ашиглагчтай гэрээ байгуулж, 100 шоо метрээс бага ус ашиглах гэрчилгээ олгох, ус ашиглагчтай байгуулсан гэрээний хугацааг сунгах, рашаан ашиглах, савлах тэмдэгтийн хураамжийг тогтоон, Гурвантэс сумын Баруун голын хэсгийн газрын доорх цэнгэг усны орд орчмын 64040 га, Номгон сумын Баянбулаг, Борзонгийн говь, Ямаат толгой, Цохиогийн хэцийн газрын доорх усны орд, Алтны гол орчмын 139904.41 га, Булган сумын Баянзагийн Нүцгэн булгийн газрын доорх усны орд орчмын 17133 га, Ханхонгор сумын Мандах, Бумбатын газрын доорх усны орд орчмын 63750 га газрыг тус тус усны эх үүсвэрийг хамгаалах зорилгоор орон нутгийн тусгай хамгаалалтад авлаа.

Мөн Түүх, соёлын дурсгалт болон үзэсгэлэнт газрын хэв шинж унаган төрхийг хадгалах, байгалийн бүс, бүслүүрийн онцлог, өвөрмөц тогтоц, ховор ургамал, амьтан бүхий нөөц газрыг хамгаалах зорилгоор орон нутгийн тусгай хамгаалалтад авсан зарим газрыг нягтлан судлах ажлын хэсэг байгуулан ажиллуулж Гурвантэс сумын Баясах баг, Ноён сумын Толь хад, Ноён богд, Саран хөндий орчмын нийт 319158 га газарт хээрийн тодруулалтын ажил хийж, тусгай хамгаалалттай газрын зарим хэсэгт давхцалыг илрүүлж, 272899,05 га газрыг орон нутгийн тусгай хамгаалалтад авч, Гурвантэс сумын Тост, Тосон бумбын орчмын газрыг улсын тусгай хамгаалалтад авах саналыг Засгийн газарт уламжилсан.



Орон нутгийн тусгай хамгаалалтад авсан зарим газрыг нягтлан судлах ажлын хэсэг-2013 он/

Түүнчлэн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нийтийн хэв журам хамгаалах ажилд олон нийтийн цагдаагийн ажилтан ажиллуулах зорилгоор аймгийн хэмжээнд ажиллах олон нийтийн цагдаагийн ажилтны тоог 24 байхаар батлаж, үйл ажиллагааг нь эхлүүлээд байна.



“Монгол тэмээ-999” арга хэмжээг 2015 оны 12 дугаар сарын 18-нд зохион байгуулж, монгол тэмээг Геннисийн номонд бүртгүүлэх арга хэмжээг зохион байгуулахаар шийдвэрлэсэн.

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурал

Эрхийн хугацаа эхлээд аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчид дунджаар 75%-ийн ирцтэйгээр 56 удаа хуралдаж, нийт 420 асуудал хэлэлцэн, 1118 заалттай, 484 тогтоол батлан хэрэгжүүлж байна. Батлагдсан тогтоолуудын 26 хувийг нийгмийн, 30 хувийг эдийн засаг, өмч санхүүгийн, 15 хувийг дэд бүтэц, хөдөө аж ахуй, байгаль орчны, 29 хувийг шагнал урамшуулал болон бусад асуудал эзэлж байна.

ХЭЛЭЛЦСЭН БАТАЛСАН ЗАРИМ ШИЙДВЭРҮҮДЭЭС ДУРДВАЛ:

- Нийгмийн бодлогын хүрээнд

Аймгийн ИТХ-аас 2013-2016 онд баримтлан ажиллах үзэл баримтлал, “Боловсрол”, “Эрүүл мэнд”, “Сүү, тараг”, “Эрүүл мэндийн шинэчлэл”, “Зөв Монгол хүүхэд”, “Авъяас”, “Аймгийн 40-өөс дээш насны ажилд ороход хүндрэлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих”, “Өрхийн эрүүл мэндийн төвүүдийг хөгжүүлэх”, “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орчныг сайжруулах”, “Эрүүл хот”, “Соёл урлагийн хөгжил”, “Архигүй Өмнөговь”, “Ажилтай орлоготой эмэгтэйчүүд”, “Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нөхөн сэргээлт”, “Өрх гэр бүлийн хөгжлийг дэмжих”, “Амьдралын буруу хэвшлээс үүдэлтэй өвчнөөс сэргийлэх, хянах” хөтөлбөр, “Шар цав, хүрдэт агуйн соёлын өвийн менежмент”-ийн /2015-2025 он/ төлөвлөгөө, Боловсролын салбарын шагналын журам, Өмнөговь аймгийн жаран мянга дахь иргэнийг тодруулах журам болон аймгийн оны есөн алдартан шалгаруулах шинэчилсэн журам батлан хэрэгжүүлж байна.



Мөн Цэргийн албыг дүйцүүлэн хаах иргэдийн нэрсийн жагсаалт батлах, Цогтцэций суманд өрхийн эрүүл мэндийн төв шинээр байгуулахыг дэмжих, “Буянт хотхон” хүүхдийн зуслангийн бүтэц зохион байгуулалт, үйл ажиллагаа, барилга байгууламжийн байдалд үнэлгээ өгөх, үйл ажиллагааг нь тогтворжуулах, Төрийн тахилгат хайрханыг тахиx, Батмөнх даян хааны дүрс бүхий лого, медаль, медалионы загвар, тайлбар батлах, Ёл шувууг Өмнөговь аймгийн бахархалт шувуугаар батлах зэрэг асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн.



- Эдийн засаг, өмч санхүүгийн бодлогын хүрээнд

Өмнөговь аймгийн өөрийгөө санхүүжүүлэх чадавх сүүлийн 5 жилд 100-395,4 хувьтай байж, жил бүр 6,8-75,5 тэрбум төгрөг буюу нийт дүнгээрээ 182,3 тэрбум төгрөгийг улсын төсөв, орон нутгийн хөгжлийн нэгдсэн санд төвлөрүүлэн, дотоодын нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлээр бүс нутагтаа нэгдүгээр, улсын хэмжээнд гуравдугаар байрт орсон амжилттай байна.

Сүүлийн 3 жилийн хугацаанд Эрүүл мэндийн салбарт нийт 24,2 тэрбум төгрөгний хөрөнгө оруулалтын ажил хийсний 40 орчим хувь буюу 9,4 тэрбум төгрөгний хөрөнгө оруулалтыг орон нутгийн төсвийн хөрөнгөөр, Боловсролын салбарт 23,2 тэрбум төгрөгний хөрөнгө оруулалт хийснээс 79,0 хувь буюу 18,5 тэрбум төгрөгний хөрөнгө оруулалтыг орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдсэн бөгөөд дэд бүтцийн салбарт орон нутгийн төсвөөс 63,2 тэрбум төгрөгний хөрөнгө оруулалт хийгджээ.

Орон нутгийн өмчийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах болон өмч хамгаалах байнгын зөвлөлийн үлгэрчилсэн журмуудыг батлан мөрдөж, орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой компаниудын ТУЗ-ын бүрэлдэхүүнийг томилох, чөлөөлөх, ТУЗ-д чиглэл өгөхээрэг орон нутгийн өмчтэй холбоотой асуудлуудыг тухай бүр шийдвэрлэхээс гадна, жил бүр орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой төсөвт байгууллага, аж ахуй нэгжийн хөрөнгийн дүнг баталж байна. Үүнд:

Орон нутгийн өмч:

сая төгрөг

Он	Балансаас балансад шилжүүлсэн	Данснаас хассан буюу актласан	Хуудлага худалдаагаар худалсан	Худалдсан	Бүртгэлд тусгасан
2012	1 384,15	3 749,96	199,88	0,50	1 164,36
2013	1 742,43	689,38	63,04	7,20	1 488,97
2014	1 257,28	469,61	81,20	4,94	73,64

Орон нутгийн өмчийн дүн:

сая төгрөг

Он	Эргэлтийн хөрөнгө		Эргэлтийн бус хөрөнгө		Нийт хөрөнгө	
	хувийн өмчийн 49%, 51%-ийг хассан дүнгээр	Нийт	хувийн өмчийн 49%, 51%-ийг хассан дүнгээр	Нийт	хувийн өмчийн 49%, 51%-ийг хассан дүнгээр	Нийт
2012	35 840,30	65 906,3	113 822,10	119 497,3	149 662,40	185 403,7
2013	57 488,60	108 275,3	158 029,10	164 115,9	215 517,70	272 391,2
2014	39 350,40	71 677,3	241 495,60	248 006,9	280 846,00	319 684,3



- Хөдөө аж ахуй, байгаль орчин, дэд бүтэц, аялал жуулчлалын хүрээнд

“Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих”, “Тонн баялаг-1 ширхэг мод” хөтөлбөр, “Аялал жуулчлал”-ын мастер төлөвлөгөө, “Ойн менежмент”-ийн төлөвлөгөө, Малчин хөтөлбөрийг хэрэгжүүлэх журам, Барилга угсралт, барилгын материалын үйлдвэрийн үйл ажиллагаанд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг хангах асуудлыг зохицуулах журам, Хилийн ойролцоо суурин газрууд болох Гурвантэс, Цогтцэций, Ханбогд сумын Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг дэмжих, Даланзадгад хотын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг шинэ суурьшлийн бүсийн ерөнхий төлөвлөгөө болгон өөрчлөх, 1000 айлын орон сууц төсөл арга хэмжээг эрчимжүүлэх, Өмнөговь аймгийг усны нэгдсэн нэг сав газрын захиргаанд хамруулахыг Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдад уламжлах, Уул уурхайн компаниудын үйл ажиллагаанд өртсөн газруудын биологийн төлөв байдлыг дүйцүүлэн хамгаалах газрын жагсаалт батлах, Малчны өдөртэй болох, Улаанбаатар Даланзадгад чиглэлийн авто зам барих ажлыг түргэтгэх зорилгоор түгээмэл тархацтай ашигт малтмал элс хайрганы үнийн хэмжээг 65 хувь болгон бууруулах зэрэг асуудлуудыг хэлэлцэж шийдвэрлэв.

- Ажлын хэсэг байгуулан ажиллах хүрээнд

Орон нутгийн тусгай хамгаалалтад авсан газрыг судлан, хамгаалалтын горимын санал боловсруулах, Ноён сумын Толь хад, Саран хөндий орчмын газар нутгийг орон нутгийн тусгай хамгаалалтад авах тухай асуудлыг судлах, Цагдаагийн албаны үйл ажиллагаанд хяналт тавих “Иргэний зөвлөлийг сонгон шалгаруулах”, орон нутгийн төсөв, хөгжлийн сангийн хөрөнгөөр 2011-2014 онд хийгдсэн арга хэмжээ бүтээн байгуулалтын ажлын чанар, үр дүн, бүртгэлд хяналт тавих, орон нутгийн өмчит “Тавантолгой” ХК-ийн нүүрсний үнийн асуудал, дотоодын хэрэгцээний нүүрсний үнийг тодорхой хугацаанд хямдруулах тухай, Баянхонгор аймгийн Шинэжинст сумаас Шивээ хүрэн хилийн боомт хүртэлх нүүрсний тээврийн замын асуудал, гүний усны ашиглалт хамгаалалтын талаар баримтлах бодлого боловсруулах зэрэг цаг хугацааны хувьд тулгамдсан асуудлууд болон иргэний танхимаас зохион байгуулж буй нээлттэй хэлэлцүүлэг тус бүрт ажлын хэсэг байгуулан ажиллуулсан бөгөөд нийт 35 ажлын хэсэг байгуулагдан ажиллаж, Тэргүүлэгчдийн хуралд ажлаа тайлагнасан байна.

- Үйл ажиллагааны тайлан, мэдээллийн хүрээнд

Бодлогын асуудал хэлэлцэн шийдвэрлэхээс гадна 2013, 2014 оны сум хөгжүүлэх сангийн хөрөнгөд хийсэн аудитын тайлан, Даланзадгад, Ханбогд, Цогтцэций сумын агаарын бохирдлын судалгаа хийсэн тухай мэргэжлийн байгууллагын мэдээлэл, Ноён сумын Толь хад, Ноён богд, Саран хөндий болон тусгай хамгаалалттай газрын асуудлыг судлах ажлын хэсгийн мэдээлэл, Хууль бусаар алт, чулуу олборлож байгаа үйл ажиллагааг таслан зогсоох талаар “Говь гурван сайхан байгалийн



цогцолборт газрын хамгаалалтын захиргаа”-нд өгсөн үүрэг чиглэлийн хэрэгжилт, Дэлхийн усны өдрийг тохиолдуулан зохион байгуулсан ажлын тайлан, аймгийн ИТХ-ын зарим хороодын хэлэлцсэн асуудлын тайлан, Төлөөлөгчдийн болон Тэргүүлэгчдийн тогтоолын хэрэгжилт, Орон нутгийн өмчит “Таван Толгой” ХК-ийн ТУЗ-ийн тайлан, Даланзадгад сумын 1, 2 дугаар бүрэн дунд сургууль, 9, 11-р цэцэрлэг, Ханхонгор, Цогтцэций сумын цэцэрлэг, Ханбогд, Хүрмэн сумын сургууль, аймгийн Боловсрол соёлын газар, “Ус Цаг Уур орчны шинжилгээний алба, Эрүүл мэндийн газар, Бүсийн оношлогоо эмчилгээний төв, “Энхийн хүслэн”, “Өнө-орших”, “Шим билэг” өрхийн эмнэлэг, Даланзадгад дулааны цахилгаан станц зэрэг албан байгууллага аж ахуй нэгжүүдийн тайланг хэлэлцэн аймгийн Засаг дарга, ЗДТГ, Засаг даргын дэргэдэх хэлтэс, агентлагуудад чиглэл хүргүүлэн ажиллаж, усыг хайрлан хамгаалах түүний үнэ цэнийг ирээдүй хойч үедээ ойлгуулах, Монгол түмний үндэсний уламжлалт цагаан сарын баярыг архигүй тэмдэглэх зэрэг уриалга гарган ажилласан.



Мөн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын чанар үр дүнд хяналт хийх, Даланзадгадын ДЦС-ын үйл ажиллагаа, дулааны шугамын байдлыг шалгаж дүгнэлт өгөх, Манлай, Ханбогд, Баян-Овоо сумдын бэлчээрийн байдал хийсэн үнэлгээний дүнг хэлэлцэх зэрэг ажлуудыг зохион байгуулж холбогдох газруудад үүрэг чиглэл өгч ажиллалаа.

Тогтоол шийдвэрийн хэрэгжилт

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн ажлын алба Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 322 дугаар тогтоол, аймгийн ИТХТ-ийн 2013 оны 68 дугаар тогтоол болон аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн ажлын албаны ажлын төлөвлөгөөний дагуу улирал бүр аймгийн ИТХ-аас баталсан тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн тайлан мэдээ, үр дүнд хяналт, дүн шинжилгээ хийж байна.

Аймгийн ИТХ-ын 6 дахь удаагийн сонгуулийн бүрэн эрхийн хугацаанд Төлөөлөгчдийн хуралдаанаас 200 заалт бүхий 50 тогтоол баталснаас 100 хувь хэрэгжиж хяналтаас хасагдсан 33 тогтоол, 70-90 хувьтай хэрэгжсэн 7 тогтоол, 60-65 хувьтай хэрэгжиж буй 3 тогтоол, хүчингүй болсон 4 тогтоол, хэрэгжилт тооцох хугацаа болоогүй 5 тогтоол байна.

Харин аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурал 2015 оны гуравдугаар улирлын байдлаар 100 хувь хэрэгжиж хяналтаас хасагдсан 389 тогтоол, 70-90 хувьтай 21 тогтоол, 40-60 хувьтай 28 тогтоол, хэрэгжилт тооцох



хугацаа болоогүй 14 тогтоол, хүчингүй болсон 2 тогтоол байна.

Зарим тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн талаар дурдвал:

2015 онд аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаар Шилэн дансны хуулийн хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт хийх ажлын хэсэг байгуулан, Даланзадгад сумын ЗДТГ, аймгийн Халамж үйлчилгээний хэлтэс, Бүсийн оношлогоо эмчилгээний төв, Ханхонгор сумын төсөвт байгууллагуудын шилэн дансны хэрэгжилтийг шалгаж, зөвлөмж өгч, тайлангаа Тэргүүлэгчдэд танилцуулав.



/Шилэн дансны хуулийн хэрэгжилт шалгах ажлын хэсэг-2015 он/

Байгаль орчны эсрэг гэмт хэргийн асуудлаар 15 сумын ИТХ-ын дарга, байгаль хамгаалагч, байгаль орчны байцаагч нарыг хамруулсан зөвлөгөөн зохион байгуулж, зөвлөгөөнөөс гарсан саналуудыг Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцэн холбогдох газруудад үүрэг, чиглэл хүргүүлсэн.



/Байгаль орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөгөөн-2015 он/

Мөн нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд олон нийтийн хяналт тавих үүрэг бүхий 5 хүний бүрэлдэхүүнтэй “Иргэний зөвлөл”-ийг аймгийн ИТХ-ын дэргэд байгуулан ажиллуулж, зөвлөлийн хагас жилийн ажлын тайланг Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцэв.



/Иргэний зөвлөлийн хурал-2015 он/

Өмнөговь аймаг “Оюу толгой” ХХК-тай байгуулах гэрээний талаар Тэргүүлэгчид хэлэлцэж, Өмнөговь аймаг, Оюу толгой ХХК-ний хамтран ажиллах гэрээнд заасан Хөгжлийг дэмжих сангийн удирдах зөвлөлд ажиллах орон нутгийн төлөөллийн бүрэлдэхүүнийг томилон, Харилцааны хороог ажиллуулах талаар аймгийн Засаг даргад үүрэг өглөө.



/Өмнөговь аймаг-Оюу Толгой ХХК-ний хамтын ажиллагааны гэрээ/

Эрхийн хугацаанд төрийн дээд шагналаар шагнуулахаар 593 хүний материалыг бүрдүүлэн Ерөнхийлөгчийн Тамгын газарт хүргүүлсэн. Үүнээс шагнагдсан иргэдийн тоог танилцуулбал:

Он	Тодорхойлогдсон иргэд	Ардын жүжигчин	Гавьяат	Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон	Цэргийн гавьяаны улаан тугийн одон	Алтан гадас	Хөдөлмөрийн хүндэт медаль	Цэргийн хүндэт медаль	Шударга журам медаль	Нийт
2012	167	-	2	6	5	42	36	-	-	91
2013	214	-	-	11	2	37	38	5	1	94
2014	314	-	-	5	2	19	40	1	-	67
2015	154	1	-	5	-	37	21	2	-	66
Нийт	849	1	2	27	9	135	135	8	1	318



/Төрийн шагнал гардуулае-2013 он/

Мөн 6 хүүхэд төрүүлж, өсгөсөн 155 эх “Эхийн алдар-1”, 4 болон түүнээс дээш хүүхэд төрүүлж өсгөсөн 425 эх “Эхийн алдар-2” одонгоор тус тус шагнагдлаа.

Төрийн дээд шагнал “Ардын жүжигчин” цолоор Өмнөговь аймгаас анх удаа Баян-Овоо сумын харьяат Төрийн хан хуурч, Монгол улсын Соёлын гавьяат зүтгэлтэн Цэенгийн Цэрэндорж шагнагдсан нь түүхэнд тодоос тод үлдэх үйл явдал боллоо.



Аймгийн 2013 оны Хүндэт иргэн Р.Батаа Аймгийн 2015 оны Хүндэт иргэн Ц.Даваацэрэн

Аймаг орон нутгийн хөгжил цэцэглэлт, ард иргэдийн сайн сайхан амьдрал, Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын тогтолцоог төлөвшүүлэх, төр, засгийн тогтоол шийдвэрийг хэрэгжүүлэхэд идэвх зүтгэл гарган, үр дүнтэй ажилласан зарим хүмүүсийг аймгийн дээд шагнал болон ИТХ-ын шагналаар шагнаж урамшуулсан. Үүнд:

Он	Батмөнх даян хааны нэрэмжит шагнал	Аймгийн хүндэт иргэн	Аймгийн хүндэт тэмдэг	Аймгийн “9 алдартан”	Аймгийн ИТХ-ын “Хүндэт жуух”	Аймгийн ИТХ-ын “Хүндэт өргөмжлөл”	Нийт
2012		1	17	9	61	31	119
2013		1	10	9	32	20	72
2014	1	1	12	9	45	35	103
2015		1	4	9	28	35	77
Нийт	1	4	43	36	166	121	371



Зохион байгуулсан ажил, үйл ажиллагааны үр дүн

Монголын тулгар төрийг хамгийн олон жил удирдсан, Алтан ургийн 31 дэх хаан Батмөнх Даян сэцэн хаан 1464 онд одоогийн Өмнөговь аймгийн Хүрмэн сумын нутаг Их Аргалант уулын “Худаг цагаан дэрстэй” гэдэг газар төрсөн болохыг Монгол Улсын Шинжлэх Ухааны академийн түүхийн хүрээлэнгийн эрдэмтэн доктор, академич, түүх судлаачид олон жилийн судалгаа шинжилгээний үр дүнд тогтоосон.

Батмөнх Даян сэцэн хаан 53 насыг наслахдаа 47 жил хаан ширээнд сууж, 37 жил төрийн хэргийг барьж, хагарч бутарсан улсаа нэгтгэн Хангайн нуруунаас түмэн газрын цагаан хэрэм хүртэлх нутагт халх түмнээ амьдруулан жаргаасан гавъяат үйлстэн билээ. Түүнийг Өмнөговь аймагт төрсөн гэдгээр нь бахархаж үйл хэргийг олонд таниулах сурталчлах, гавъяа үйлсийг мөнхжүүлэх үүднээс 2014 онд түүний мэндэлсний 550 жилийн ойн арга хэмжээг зохион байгуулсан.

Ойн хүрээнд Батмөнх даян хааны хүй цөглөсөн газарт хүндэтгэл үзүүлж, 550 жилийн ойн лого, медаль, медалионы уралдаан зарлан дүгнэж, даян хааны тухай дуу бүтээн, “Бидний бахархал” ном хэвлүүлэн, хааны нэрэмжит “Язгуур урлагын наадам”, “Хаан удамт сүлдэн говь” концерт, “Шилмэл хурд 2014” хурдан морины уралдаан, Үндэсний сурын болон шагайн харвааны улсын аварга шалгаруулах тэмцээн зэрэг арга хэмжээг улс, аймаг орон нутагт амжилттай зохион байгуулж, даян сэцэн хааны хөшөөг Нутгийн удирдлагын ордны урд талбайд сүндэрлүүлэн босгож, хааны нэрэмжит шагнал бий болголоо.



Батмөнх даян сэцэн хаан Батмөнх даян сэцэн хааны хүй цөглөсөн газар Хүрмэн сумын нутаг



Батмөнх даян сэцэн хааны хөшөө

Батмөнх даян сэцэн хааны нэрэмжит медаль



Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчид, ажлын албаны “Нээлттэй өдөрлөг”-ийг анх удаа аймаг, сумдын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлыг хамруулан зохион байгуулж, тогтоол шийдвэр, үйл ажиллагаагаа олон нийтэд нээлттэй мэдээллэн, сумдын ИТХ-ыг туршлага судлах боломжоор хангалаа.



Аймаг, сумдын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нээлттэй өдөрлөг 2013 он

Монгол улсад ардчилсан шинэ Үндсэн хууль батлагдсан өдрийг тохиолдуулан Үндсэн хууль батлагдсан өдрийг иргэдэд сурталчлах, хуулиа дээдлэх үзлийг төлөвшүүлэх зорилгоор Үндэсний бөхийн барилдаан, аймгийн аварга шалгаруулах шатрын тэмцээн, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нэрэмжит гар бөмбөгийн тэмцээн, Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдын дунд илтгэл, эссэ бичлэгийн уралдаан зохион байгуулж, Шинэ үндсэн хуулийг батлахад аймаг орон нутгаа төлөөлөн оролцсон ахмад депутатуудад хүндэтгэл үзүүлэх арга хэмжээ уламжлал болон амжилттай зохион байгуулагдаж байна.



Үндэсний бөхийн барилдаан



Аймгийн аварга шалгаруулах шатрын тэмцээн



“Үндсэн хуулийг хэн сайн мэдэх вэ” сэдэвт илтгэл, эссэ бичлэгийн уралдаан



Төрийн албан хаагчдын дунд гар бөмбөгийн тэмцээн



Мөн Үндсэн хууль, олон улсын гэрээ, конвенц болон хууль тогтоомжоор баталгаажсан иргэдийн эрх, эрх чөлөө, түүний хэрэгжилтийн байдалд судалгаа, дүн шинжилгээ хийх, Өмнөговь аймагт уул уурхайн хайгуул, олборлолтын үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны хүний эрхэд нөлөөлөх байдлыг үнэлэх, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийн хэрэгжилтийг хангах зорилгоор “Хүний Эрхийн Үндэсний Комисс”-той хамтран ажиллах “САНАМЖ БИЧИГ” байгуулан ажиллаж байна.



Хүний эрхийн үндэсний комиссттой хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурав-2014 он

Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагаболонзахиргааныбайгууллагын шийдвэрт иргэдийн байр суурь, үзэл бодлыг тусгах, иргэдийн санал бодлыг дээд шатны шийдвэр гаргагчдад сонгох, олон нийтийн санаа зовоож буй асуудлаар нээлттэй

хэлэлцэх зорилготой ажилладаг аймгийн Иргэний танхим 2013-2015 онд орон нутгийн тулгамдсан “Төсөв дэх иргэдийн оролцооны чиглэлээр-3 удаа, Боловсрол-4 удаа, эрүүл мэнд-3, байгаль орчны чиглэлээр-7 удаа, төрийн үйлчилгээ, тендер, түүний ил тод байдал, авлига, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зэрэг 30 асуудлуудаар иргэдийн оролцоог нэмэгдүүлэх үүднээс төлөвлөсөн хэлэлцүүлгүүдийг 2-3 үе шаттайгаар зохион байгуулж нийт 60 удаагийн нээлттэй хэлэлцүүлэг зохион байгууллаа.

Зохион байгуулсан хэлэлцүүлэгт төр, хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байгууллага, иргэд, олон нийтийн байгууллагын төлөөлөл болох 13429 хүн хамрагдаж, 2879 санал санаачлага гарсныг нэгтгэн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдэд танилцуулан нийт саналын 1700 гаруй санал буюу 60 хувийн санал нь аймгийн ИТХТ-ийн 153 заалт бүхий 45 тогтоол шийдвэрт тусч хэрэгжилтийг тооцон ажиллаж байна.



Иргэний танхимын хэлэлцүүлэг-2013 он



Мөн аймгийн Иргэний танхим иргэдийг мэдээллээр хангах зорилгоор төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран хүний эрх, эмэгтэйчүүд манлайлал, байгаль орчны нөхөн сэргээлт гэх мэтчилэн тодорхой чиглэлүүдээр 50-иад төрлийн сургалт зохион байгуулан ажиллаж байна.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын даргын санаачлагаар 2013 онд “Хүүхдээ сонсоё” арга хэмжээ зохион байгуулж, Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын дэргэд Хүүхдийн дуу хоолой, санал бодлыг сонсох, хүүхдийн өөрөө удирдах байгууллагыг дэмжих, шийдвэр гаргагч, хэрэгжүүлэгч байгууллагад хүүхдийн санал, бодол, хүсэл тэмүүллийг хүргэх, тэдэнтэй хамтарч ажиллах үйл ажиллагааг эрчимжүүлэх зорилгоор 2014 онд Даланзадгад сумын Ерөнхий боловсролын 4 сургууль, политехникийн коллежийн ахлах анги бүрээс сонгогдсон 39 сурагчдын бүрэлдэхүүнтэй “МИНИ ПАРЛАМЕНТ”-ыг байгуулан, дөрвөн удаагийн хуралдаан зохион байгуулаад байна.



Хүүхдээ сонсоё арга хэмжээ-2013 он

Мини парламентын хуралдаанаар дарга, нарийн бичгийн даргыг сонгон томилж, гишүүдийг Нийгмийн бодлого, Ёс зүй, Урлаг, спорт, Мэдээлэл сурталчилгаа, Байгаль орчин гэсэн 5 хороонд хуваарилан, салбар тус бүрт тулгамдаж байгаа асуудлуудыг хэлэлцэн, шийдвэрлэх арга замыг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдэд танилцуулан ажиллаж, холбогдох албан байгууллагуудад саналыг хүргүүлээ.



Мини парламентын хуралдаан

Мөн Өмнөговь аймгийн сурагчдын чуулга уулзалт зохион байгуулах, ЕБСургууль болон Политехник коллежийн нийт сурагчдыг хамруулан



“Хоггүй хот –хүүхэд биднээс” уриан дор хагас жилд нэг удаа их цэвэрлэгээ зохион байгуулах ажлуудыг санаачлан, зохион байгуулаад байна.



Цогтцэций сумын Мөрөөдөл сургуультай танилцав



“Хоггүй хот-хүүхэд биднээс” их цэвэрлэгээ

Аймгуудын өрсөлдөх чадварын судалгаагаар Өмнөговь аймаг нь 2013 онд 21 аймгаас Орхон аймгийн дараа 2 дугаарт эрэмблэгдсэн. Үүнээс үүдэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын санаачлагаар аймгийнхаа 15 сумын өрсөлдөх чадварын судалгааг хийлгэн, сумдууд эдийн засаг, засаглалын үр ашиг, бизнесийн үр ашиг, дэд бүтэц гэсэн үндсэн үзүүлэлтүүдээ сайжруулах боломжтой болоод байна.



Сумдын өрсөлдөх чадварын тайлангийн ном

ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН АЖИЛ, ҮР ДҮН

Аймгийн ИТХТ-ийн шийдвэрээр ажлын хэсэг байгуулан тодорхой асуудлуудаар хяналт шалгалт хийсэн төдийгүй аймгийн ИТХ-ын хуралдаан, ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаас баталсан тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд улирал бүр хяналт тавин үр дүнг тооцон ажиллаж байгаа бөгөөд тайлангаа хугацаанд нь ирүүлээгүй, биелэлтийг тооцоогүй, хэрэгжилт хангалтгүй тогтоол шийдвэрүүдэд анхаарлаа хандуулан холбогдох хэлтэс албадад чиглэл өгч ажиллалаа.

Мөн аймгийн Аудитын газарт Баян-Овоо, Цогтцэций, Ханбогд сумдын түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашиглалт, уул уурхайд ашиглаж байгаа усны нөөц ашиглалт, орон нутгийн өмчит “Таван толгой” ХК, “Гүний ус” ХК-ийн орон нутгийн 51 хувийн өмчийн үр ашиг, Өмнөговь аймагт авто тээвэр өөрөө явагч хэрэгслийн албан татварын орлогын бүрдүүлэлт, аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн гүйцэтгэл, түүний үр дүн, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын чанар, үр дүн зэрэг асуудлаар захиалгат аудит хийлгэн ажиллаа.



Тухайлбал:

- **Даланзадгад, Цогт-цэций, Ханбогд, Баяновоо, Гурвантэс сумдын түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц** ашигласны төлбөрийн ногдуулалт, төлөлтөнд гүйцэтгэлийн аудит хийлгэхэд, Өмнөговь аймгийн хэмжээнд түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглах ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээд байхгүй байсан байна.

Баяновоо, Гурвантэс сум гэрээг дутуу байгуулсан, Ханбогд сум гэрээндээ түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглах хэмжээ ногдох төлбөрийг тусгаагүй зэрэг зөрчил дутагдал илэрсэн байна.

- **Авто тээвэр болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын** ногдуулалт, орлого бүрдүүлэлтийн талаар аймгийн аудит хяналт шалгалт хийж үзэхэд Өмнөговь аймагт бүртгэлтэй тээврийн хэрэгслийн тоо зөрүүтэй, авто тээврийн үндэсний төвийн Өмнөговь аймаг дах салбараас 13848 тээврийн хэрэгсэл, Авто тээврийн үндэсний төвөөс 15467 гэсэн тоо байгаагаас 1628 тээврийн хэрэгсэл зөрүүтэй, мөн зарим ачааны авто машины болон чиргүүлийн даац, трактор өөрөө явагч хэрэгсэл, бага оврын трактор, тусгай зориулалтын авто машины хөдөлгүүрийн багтаамж, ачааны авто машины даацын хэмжээг буруу бүртгэсэн, авто машин эзэмшигчдийн хөдөлгөөний бүртгэлийг хийгээгүй зэрэг зөрчил илэрсэн байна.

- **Уул уурхайд ашиглаж байгаа усны нөөцийн ашиглалтын** байдалд хяналт хийхэд 6 тэрбум 402 сая төгрөгийн дутуу төлөлттэй байсан нь 2013 оны төсвийн орлого тасархад нөлөөлсөн байна. Үүнээс үүдэн бүх шатны ИТХ, Засаг дарга нар “Усны тухай хууль”-д заасан бүрэн эрхээ хэрэгжүүлж, усны төлбөр ногдуулалт, төлөлтөд хяналт тавьж ажиллахыг анхааруулсан.

- **Орон нутгийн өмчит** “Таван толгой” ХК, “Гүний Ус” ХХК-ийн үйл ажиллагаа түүний үр ашгийн байдалд 2013 онд аудит хийлгэхэд “Таван Толгой” ХК нь 2012 онд Уулын ажлын төлөвлөгөө, ТУЗ-аас баталсан “Бизнес төлөвлөгөө”-ний дагуу 15,5 сая м3 хөрс хуулахаас, 13,2 сая метр3 хөрс хуулалтын ажлыг хийж 2,3 сая тонн нүүрс олборлон, 2,2 сая тонн нүүрсийг гадаадын зах зээлд, 100 мянган тонн нүүрсийг дотоод зах зээлд борлуулсан байна. Тус компанийн 2012 оны үйл ажиллагаа нь тасралтгүй явагдсан боловч 5, 8 сард Таван толгой–Гашуун сухайт чиглэлийн шороон замыг хаасантай холбоотойгоор нүүрс тээвэрлэх үйл ажиллагаа саатсан, БНХАУ-ын нүүрс худалдан авалтын хэмжээ багасч, нүүрсний зах зээлийн үнэ буурсан нь компанийн нүүрс олборлох, борлуулах төлөвлөгөө тасрахад зохих хэмжээгээр нөлөөлсөн гэсэн дүгнэлт гарсан байна.

“Гүний ус” орон нутгийн өмчийн оролцоотой ХХК-ний хувьд компанийн өөрийн хөрөнгийн хэмжээ санхүүгийн тайлан, улсын бүртгэлийн гэрчилгээнд тусгасан хөрөнгийн хэмжээнээс зөрүүтэй байсан байна.

Тус компани үйл ажиллагаандаа “Орон нутгийн хотуудын нийтийн аж ахуйн хөгжлийн хоёрдугаар үе шатны төсөл” хэрэгжүүлж, Даланзадгад хотын төвийн хуучин ган шугам сүлжээг орчин үеийн сайжруулсан шугамаар шинэчлэн, Баруун сайханы 8, 9, 10 дугаар гудамж дахь айл өрхийг цэвэр



усны шугамд холбосон, 10 ба 20 дугаар усан сангийн шугамыг шинэчилсэн нь орон нутгийн иргэдийн амьдрах нөхцөл сайжрах, аж ахуй нэгжийн үйлдвэр үйлчилгээгээ нэмэгдүүлэхэд үр өгөөж өгч байна гэж дүгнэжээ.

Мөн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс 2013 онд баталсан “Эрүүл мэндийн шинэчлэл”, “Өрхийн эрүүл мэндийн төвүүдийг хөгжүүлэх” хөтөлбөрүүдийн хүрээнд хийгдсэн 5,3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтад аймгийн аудитын газар гүйцэтгэлийн аудит хийж, тайланг ирүүлсэн.

Эрүүл мэндийн салбарт хийгдсэн хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийг зориулалтаар нь авч үзвэл 80% буюу 4,0 тэрбум төгрөгийг эмнэлгийн тоног төхөөрөмжинд, 15% буюу 776,5 сая төгрөгийг авто машин тээврийн хэрэгсэлд 3% буюу 121,4 сая төгрөгийг сургалт, хөтөлбөрт, 1% буюу 43,0 сая төгрөгийг техник хэрэгсэлд, мөн 1% буюу 62,8 сая төгрөгийг зураг төсөв, их засварт тус тус зарцуулагдсан байна.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчид Ноён, Гурвантэс сумын орон нутгийн тусгай хамгаалалтад авсан газруудад тусгай хамгаалалтын орчны бүс тогтоох ажлыг зохион байгуулж ажилласан ба Гурвантэс суманд байгаль орчны нээлттэй өдөрлөг зохион байгуулж орон нутгийн ард иргэдтэй байгаль орчин, тусгай хамгаалалттай газар нутгийн талаар санал хүсэлтийг сонсож зарим санал хүсэлтийг үйл ажиллагаандаа тусган хэрэгжүүлэн ажиллаж байна.



Ажлын хэсэг ноён Гурвантэс сумдад ажиллав-2013 он

Түүнчлэн аймгийн ИТХ-ын дарга, Тэргүүлэгчид аймгийн цэвэр усны нөөц болох Балгасан голын улаан нуурын талбайд “Пибоди винсвэй ресорсез”



Тэргүүлэгчид Балгасан голын улаан нуурын орчимд-2014 он



ХХК-ийн лицензийн талбай давхацсан хэсгийн байршил тогтоох ажлын хэсэг байгуулан ажиллалаа.

Дэлхийн усны өдрийг тохиолдуулан аймгийн ИТХ-ын даргаар ахлуулсан ажлын хэсэг Өмнөговь аймагт уул уурхай эрхэлж байгаа “Оюу-Толгой”, “Энержи ресурс”, “Эрдэнэс таван толгой” гэх мэт ХХК-уудын хөрсний болон гүний ус ашиглалтын байдал, “Оюу-Толгой” ХХК-ний ус ашиглалт, гадаргын усны шүүрэлтэй байгаа 6 цооногтой газар дээр танилцаж, зохих арга хэмжээ авч ажиллахыг тус тус зөвлөсөн.

СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГАА

Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчид, ажлын алба нь Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагыг төлөвшүүлэх, үйл ажиллагааг тогтмолжуулах зорилгоор сумдын хурлын байгууллагын хагас бүтэн жилийн ажлын тайлантай танилцан, жил бүр үйл ажиллагаанд нь мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилладаг.



/Мандал-Овоо сум/



/Цогтцэций сум/

Сумдын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагааны дүгнэлт

Он	Тэргүүн байр	Дэд байр	Гутгаар байр
2012	Даланзадгад	Баян-Овоо	Сэврэй
2013	Сэврэй	Гурвантэс	Баян-Овоо
2014	Сэврэй	Даланзадгад	Номгон

Улсын Их Хурлын гишүүн Д.Бат-Эрдэнийн санаачлага, дэмжлэгээр Монголын Нутгийн Удирдлагын холбооноос зохион байгуулсан “Чадвартай хариуцлагатай ИТХ-ыг бэхжүүлэх арга зам” сэдэвт сургалтанд бүх сумын ИТХ-ын Төлөөлөгчид, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн ажлын албаны ажилтан, сумдын ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга нар хамрагдлаа.

Мөн Авилгатай тэмцэх газар, Монголын Нутгийн Удирдлагын холбооноос хамтран зохион байгуулсан хөрөнгө орлогын мэдүүлэг хүлээн авах эрх бүхий албан тушаалтны сургалтанд аймаг, сумдын ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга нар хамрагдсан бөгөөд Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг



зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, түүнчлэн мэдүүлгийг бүрдүүлэлтийн цахим программ хангамжийн талаарх сургалтанд аймаг сумдын ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга, ЗДТГ-ын дарга, зарим агентлагийн эрх бүхий албан тушалтнууд хамрагдсан болно.



Дорноговь аймаг-2013 он



Аймгийн Иргэний танхим-2014 он

Нутгийн өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагааг төлөвшүүлж, аймаг, сумдын Хурлын байгууллагын Төлөөлөгч, Тэргүүлэгч, БИНХ-ын дарга, ажилтнуудыг бусад аймаг, сумдын ажилын туршлагыг судлуулах, шинэ мэдээ, мэдээллээр хангахад анхаарч сумдын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, багийн Иргэдийн Нийтийн хурлын Төлөөлөгч, Тэргүүлэгч, ажилтнуудыг хамруулсан нэгдсэн арга хэмжээг Сэврэй, Баян-Овоо суманд зохион байгуулж, Хүний эрхийн хуульч Н.Ичинноровыг урьж ирүүлэн “Иргэдийг төлөөлөх”, “Иргэддээ тайлагнах”, “Манлайлал” сэдвүүдээр сургалт зохион байгуулсан бөгөөд сум тус бүр өөрийн ажлын



Нэгдсэн арга хэмжээ, Сэврэй-2014 он



Сургалт, Сэврэй-2014 он



Нэгдсэн арга хэмжээ, Баян-Овоо сум-2015 он





онцлог давуу талыг бусаддаа танилцуулж, урлаг спортын нөхөрсөг тэмцээн зохион байгууллаа.

Сэврэй сумын нэгдсэн арга хэмжээний үеэр сумдын ИТХ-ын Тэргүүлэгчдийн ажлын албаны ажиллах орчин нөхцлийг сайжруулах, үйл ажиллагааг төлөвшүүлэх зорилгоор 80 сая төгрөгний тендер зарлаж, сум бүрт компьютер, принтер, проектор, сканер, канон, зургийн аппарат, дуу хураагуур /диктафон/ зэрэг шаардлагатай тоног төхөөрөмжийг хувиарлан олголоо.



Нэгдсэн арга хэмжээ, компьютер техник хэрэгсэл гардуулав. Сэврэй-2014 он

Улсын Их Хурлын Тамгын газар, НҮБХХ, Швейцарын хөгжлийн агентлаг, Аймгийн ИТХ хамтран Төлөөлөгчийн эрх үүрэг, ИТХ-ын дотоод зохион байгуулалт, төсөв санхүү, авилга, ашиг сонирхолын зөрчлөөс сэргийлэх, байгаль орчин, хүний эрх, иргэдийн оролцоо зэрэг сэдвүүдээр 15 сумын ИТХ-ын 324 Төлөөлөгчдөд сургалт зохион байгууллаа.



Аймаг, сумдын ИТХ-ын Төлөөлөгчдийн сургалт-2013 он

Төсвийн шинэ хууль, “Шууд ардчилал-Иргэдийн оролцоо” сэдэвт сургалтанд аймаг, сумын ИТХ-ын дарга, Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга нар хамрагдлаа.



/Сумдын ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга нарын сургалт/



Мөн УИХ-ын Тамгын газар, НҮБ-ын хөгжлийн хөтөлбөр, Швейцарийн хөгжлийн агентлагаас хэрэгжүүлж буй “Нутгийн өөрөө удирдах байгууллагын чадавхийг бэхжүүлэх нь” төслийн хүрээнд аймаг, сумдын ИТХ-ын эмэгтэй Төлөөлөгчдөд “Нутгийн удирдлагад эмэгтэйчүүдийн манлайлал” сургалтыг зохион байгуулж, ИТХ-ын портал, интерактив цахим хуудасны сургалтыг бүх сумдын ИТХ-ын нарийн бичгийн дарга нар, ажилтнуудад зохион байгууллаа.

Мерси Кор ОУБ-ын санхүүжилтээр Монголын Нутгийн удирдлагын холбоотой хамтран сумын мастер төлөвлөгөө боловсруулах арга зүйн сургалтыг Гурвантэс, Манлай, Ханбогд, Ханхонгор, Сэврэй, Цогтцэций сумдыг хамруулан зохион байгуулж мастер төлөвлөгөө боловсруулах ажил хийгдсэн ба зарим сумдын ИТХ Төлөөлөгчдөө Удирдлагын академи болон Нутгийн удирдлагын холбооны сургалтанд хамруулаад байна.



Цогтцэций сум-2014 он

Төвийн бүсийн аймгуудын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид, ажлын албаны ажилтнуудын туршлага солилцох уулзалт Дорноговь, Өмнөговь, Сэлэнгэ, Дархан, Дундговь аймгуудад зохион байгуулагдаж, харилцан туршлага судлаж, мэдээлэл солилцон, МУ-ын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, сонгуулийн нэгдсэн хуулиудын төсөлд санал боловсруулан нэгтгэж Монгол Улсын Их хурал, Засгийн газар болон Нутгийн удирдлагын холбооны 20 жилийн ойн нэгдсэн зөвлөгөөнд саналаа хүргүүллээ.




Сэлэнгэ аймаг-2015 оны 06 сар



Өмнөговь аймаг-2014 оны 09 сар

Аймгийн ИТХ-ын байнгын тасралтгүй үйл ажиллагааг хангах үүрэг бүхий Тэргүүлэгчид өөрийн бүрэн эрхийн хүрээнд хэлэлцэн шийдвэрлэсэн асуудлуудаар улирал бүр тогтоолын эмхтгэл гарган Төлөөлөгчдөд хүргүүлэн ажиллаж байгаа бөгөөд УИХ-ын Тамгын газар, НҮБ-ын хөгжлийн хөтөлбөр, Швейцарийн хөгжлийн агентлагаас хэрэгжүүлж буй төслийн хүрээнд аймаг, сумдын ИТХ-ын портал, интерактив цахим хуудастай болгож, цахим хуудсаар дамжуулан үйл ажиллагаагаа сурталчилж байна.



ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Аймгийн ГХУСАЗЗөвлөл нь улирал бүр тогтмол хуралдаж цаг үеийн болон тулгамдсан асуудлуудыг хэлэлцэн, тодорхой арга хэмжээ зохион байгуулдаг бөгөөд Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Архигүй Монгол”, Монгол Улсын Засгийн газрын “Олон нийт цагдаагийн хамтын ажиллагаа”, “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх мэдээлэл, сурталчилгаа”, “Сэтгэцийн эрүүл мэнд” зэрэг хөтөлбөр, санаачилга, чиглэл, даалгаврыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулан, хэрэгжилтийг тооцон ажиллаж байна.

Тухайлбал 2014 онд Даланзадгад сумын зам тээврийн осол их гардаг цэгүүдэд замын тэмдэг тэмдэглэгээ, камержуулалт, хурд сааруулагч тавих шийдвэр гарган, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээр “Архигүй Өмнөговь” хөтөлбөрийг батлуулан, хэрэгжүүлж байна.



Архигүй-Өмнөговь хөтөлбөрийн нээлт-2014 он

Тус хөтөлбөрийг сумдад хэрэгжүүлэн ажиллах салбар зөвлөлийг байгуулан, АА цуглааны үйл ажиллагааг дэмжиж үйл ажиллагааг нь тогтмолжуулан “Говийн наран” бүлгийн 1 жилийн ойн арга хэмжээг зохион байгуулж ажилласаны үр дүнд 26 иргэнийг архидан согтуурах хорт зуршлаас нь салгаж, эрүүл зөв амьдралд татан оруулсан байна.



Гэнэтийн шалгалт арга хэмжээ-2014 он

Архигүй Өмнөговь хөтөлбөрийн хүрээнд согтууруулах ундаа худалдах, хэрэглэх, түүгээр үйлчлэх цэгүүдэд хяналт шалгалт хийж нийт 20 аж ахуй нэгжүүдийн согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийг түтгэлзүүлэн, 23 аж ахуй нэгжүүдийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон байна.

Байгаль орчны эсрэг гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх чиглэлээр аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Мэргэжлийн хяналтын газар, аймгийн Прокурорын газар, Цагдаагийн газар хамтран Гурвантэс сумын Урт баг, Ноён, Сэврэй сумын нутаг дэвсгэрт хууль бус ашигт малтмал эрэх хайх, олборлох ажиллагаанд хяналт шалтгалт хийж, байгаль орчны хууль тогтоомжийн эсрэг үйлдлийг таслан зогсоож, техникийн нөхөн сэргээлт хийн, хяналтын ажлыг эрчимжүүлэн ажиллаж байна.

“Говийн ирээдүйн эзэд” хоёр сарын аян, “Хүчирхийлэл ба хяналт” нэг сарын аян, аюулгүй орчинг-хамтдаа бүрдүүлье уриатай “Замын хөдөлгөөний цагаан толгой-2013” арга хэмжээ, “Мал хамгаалах тэргүүний бүлэг нөхөрлөл шалгаруулах” зэрэг нэгдсэн арга хэмжээнүүдийг зохион байгуулж хэрэгжилтийг тооцон ажилласан.



Иргэн ба хууль-11, Ногоон гэрэл, цагаан шугам-2014 он



ЦАГААТГАХ АЖЛЫГ УДИРДАН ЗОХИОН БАЙГУУЛАХ САЛБАР КОМИССЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Аймгийн ИТХ-ын үйл ажиллагаатай салшгүй холбоотой нэг ажил бол Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах салбар зөвлөлийн ажил байдаг.

Монгол улсын Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах комисс /ЦАУЗБК/-ын мэдээллийн санд манай аймгийн 35 иргэн нөхөн олговороо хөөцөлдөж байгаа судалгаа байгаа боловч идэвхтэй хөөцөлдөж байгаа 4 иргэн байна.

2013-2015 онд ЦАУЗБК давхардсан тоогоор нийт 180 иргэнтэй уулзаж, 46 өргөдөл хүлээн авч, гурван хүнд цагаатгалын 2,5 сая төгрөг олгон, хэлмэгдэгсдийн ар гэрийн 5 хүнийг ахмадын сувилалд амрууллаа.

Мөн хэлмэгдэгсдийн дурсгалыг хүндэтгэх өдрийг тохиолдуулан цагаатгагдсан иргэдийн нэр төрийг сэргээх, дурсгалыг мөнхжүүлэх, хэлмэгдүүлэлтийн хор уршгийг сурталчлах, улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийн ар гэр, үр хүүхдийн судалгааг нарийвчлан гаргаж Цагаатгах ажлын удирдан зохион байгуулах улсын комисст хүргүүллээ.



АЙМГИЙН УЛААН ЗАГАЛМАЙН ХОРООНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА

ИТХ-ын даргын хариуцан ажиллаж, Тэргүүлдэг байгууллагын нэг нь Улаан загалмайн хорооны үйл ажиллагаа байдаг.



Улаан загалмайн хорооны удирдах зөвлөлийн хурал



Улаан загалмайн говийн бүсийн сургалт

Аймгийн Улаан загалмайн хороо нь Эрүүл мэндийг дэмжих, Нийгмийн халамж, Хүүхэд залуучууд, Гамшгийн менежмент гэсэн 4 үндсэн хөтөлбөрийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулж, 2012-2015 онд Хүмүүнлэг, Эрүүл мэндийн анхны тусламжийн, БЗДХ, ХДХВ, ДОХ-той тэмцэх, Донор сурталчилгаа, Гамшгийн бэлэн байдал, Халамж үйлчилгээний, Залуучуудын



улаан загалмай, Мэдээлэл сурталчилгаа гэсэн хөтөлбөрүүд, “Залуучууд хөдөлгөөнт болон эрсдэлт бүлгийн хүн амыг БЗДХ/ХДХВ-ийн халдвараас сэргийлэх”, “Гамшгийн эрсдэлийг бууруулах олон нийтийн чадавхийг бэхжүүлэх” зэрэг томоохон төслүүдийг хэрэгжүүлж ажиллалаа.



Нийгмийн халамж хөтөлбөрийн тусламж



Эрүүл мэндийн хөтөлбөрийн сургалт

Аймгийн Улаанзагалмайн хорооноос хэрэгжүүлдэг 4 үндсэн хөтөлбөрийн хүрээнд 2013-2015 онд хамрагдсан иргэдийн тоог хүснэгтээр харуулбал:

Улаан загалмайн хөтөлбөр	2013 он	2014 он	2015 он	Нийт
Нийгмийн халамжийн хөтөлбөрт хамрагдсан иргэдийн тоо	1320	1459	1732	4511
Нийгмийн эрүүл мэндийг дэмжих хөтөлбөрт хамрагдсан иргэдийн тоо	5094	5888	7541	18523
Гамшгийн менежментийн хөтөлбөрт хамрагдсан иргэдийн тоо	2558	3233	3781	9572
Хүүхэд залуучуудын хөтөлбөрт хамрагдсан иргэдийн тоо	2958	3278	3738	9974
Нийт	11930	13858	16792	42580



Хүүхэд залуучуудын хөтөлбөрийн сургалт



Гамшгийн менежментийн хөтөлбөрийн сургалт

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид Улаан загалмайн хүмүүнлэгийн үйлсийг бусдад уриалан манлайлж, хүмүүнлэгийн хөтөлбөрт нэгдэн хандив өгч, “Улаан загалмайн Онцгой гишүүн”-ээр элслээ.

Улаан загалмайн хорооноос 2014 онд “Та энэрэнгүй сэтгэлтэн” хүмүүнлэгийн аяныг зохион байгуулж нийт 62 байгууллага оролцсон бөгөөд



гишүүд дэмжигчид 902, онцгой гишүүд 36, сайн дурын идэвхтэн 21-ээр тус тус нэмэгдсэн байна.

2014 оны Монгол бахархалын өдрөөр аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, Улаан загалмайн хороо хамтран гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хүмүүнлэгийн үйл ажиллагааг сурталчлах, туршлага солилцох, ажлын хүрээнд төрийн байгууллага, агентлагуудын дарга, удирдлагуудын дунд гар бөмбөг, сагсан бөмбөг, дартс шидэлтийн төрлүүдээр нөхөрсөг тэмцээнийг зохион байгуулж, улаан загалмайн хүмүүнлэгийн үйл ажиллагаанд 1,4 сая төгрөгний хандив бүрдүүлэн, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 14 байгууллага тайлан, туршлагаа танилцууллаа.



Монгол бахархалын өдөрт зориулсан арга хэмжээ-2014 он

АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТӨЛӨӨЛӨГЧИД /2012-2016/

№	Сум	Сонгогдсон тойрог	Овог Нэр	Намын харьяалал	Тайлбар
1.	Баяндалай	1-р тойрог	Раднаагийн Бадрах	АН	Төлөөлөгч
2.	Баян-Овоо	2-р тойрог	Хорлоогийн Батболд	МАН	Тэргүүлэгч
3.	Булган	3-р тойрог	Намсрайн Амарзаяа	МАН	Төлөөлөгч
4.	Гурвантэс	4-р тойрог	Гэлэнбандийн Гангамаа	АН	Төлөөлөгч
5.	Мандал-Овоо	5-р тойрог	Цэдэвдоржийн Мөнхнасан	АН	Төлөөлөгч
6.	Манлай	6-р тойрог	Рэнцэндоржийн Бурмаа	МАН	Төлөөлөгч
7.	Номгон	7-р тойрог	Түмэнбаярын Золжаргал	АН	Төлөөлөгч
8.	Ноён	8-р тойрог	Багварын Жаргал	МАН	Төлөөлөгч
9.	Сэврэй	9-р тойрог	Хумбаагийн Түмэндэлгэр	АН	Тэргүүлэгч
10.	Ханбогд	10-р тойрог	Бямбацогтын Эрдэнэ-Очир	МАН	Төлөөлөгч
11.	Ханхонгор	11-р тойрог	Жамцын Отгонбаяр	МАН	Төлөөлөгч
12.	Хүрмэн	12-р тойрог	Шоовдорын Баянбат	АН	Төлөөлөгч
13.	Цогт-Овоо	13-р тойрог	Ренчинбямбын Сэддорж	АН	Тэргүүлэгч
14.	Цогтцэций	14-р тойрог	Наранцэцэгийн Амгалан	АН	Тэргүүлэгч



15.	БС 1-р баг	15-р тойрог	Жаалхүүгийн Тунгалаг	АН	Тэргүүлэгч
16.	ХУ 2-р баг	16-р тойрог	Хүүгийн Түмэнбаяр	АН	Төлөөлөгч
17.	Далан 3-р баг	17-р тойрог	Лувсангийн Цэцэг-Өлзий	АН	Төлөөлөгч
18.	ДС 4-р баг	18-р тойрог	Доржпаламын Нацагдорж	АН	Тэргүүлэгч
19.	ЗС 5-р баг	19-р тойрог	Бараадуузын Батаа	МАН	Тэргүүлэгч
20.	Начин 6-р баг	20-р тойрог	Насанбуянгийн Энхбат	АН	Тэргүүлэгч
21.	Оюут 7-р баг	21-р тойрог	Жамъянжавын Сандаг	АН	Төлөөлөгч
22.	Цагаан/б 8-р баг	22-р тойрог	Бодийн Мятав	АН	Төлөөлөгч
23.	Хувь тэнцүүлэх	23-р тойрог	Лувсангийн Энхболд	МАН	Төлөөлөгч
24.	Хувь тэнцүүлэх	24-р тойрог	Пүрэвийн Пүрэвжав	МАН	Төлөөлөгч
25.	Хувь тэнцүүлэх	25-р тойрог	Өлзийхутагийн Баянмөнх	МАН	Төлөөлөгч
26.	Хувь тэнцүүлэх	26-р тойрог	Ваанчигийн Мөнхбат	МАН	Тэргүүлэгч
27.	Хувь тэнцүүлэх	27-р тойрог	Бадамгаравын Бадраа	АН	Төлөөлөгч
28.	Хувь тэнцүүлэх	28-р тойрог	Лхачингийн Батчулуун	АН	ИТХ-ын дарга
29.	Хувь тэнцүүлэх	29-р тойрог	Аюурзанын Жаргалсайхан	АН	Тэргүүлэгч
30.	Хувь тэнцүүлэх	30-р тойрог	Авирын Идэрцог	АН	Төлөөлөгч
31.	Хувь тэнцүүлэх	31-р тойрог	Борхүүгийн Цэвээн	АН	Төлөөлөгч
32.	Хувь тэнцүүлэх	32-р тойрог	Цэцэгээгийн Бяцхансүх	АН	Төлөөлөгч
33.	Хувь тэнцүүлэх	33-р тойрог	Дагдангийн Эрдэнэ	МАХН	Төлөөлөгч

“АЙМГИЙН ХҮНДЭТ ИРГЭН”-Р ШАГНАГДСАН ИРГЭД

№	Он	Овог нэр	Эрхэлдэг ажил
1	2006	Тойвгын Наранхүү	Төр, нийгмийн зүтгэлтэн
2	2007	Цэдэнжамцын Банди	Монгол Улсын хөдөлмөрийн баатар
3	2008	Даваасүрэнгийн Жижээ	Монгол Улсын хөдөлмөрийн баатар
4	2009	Хоролын Цэвэгмэд	Монгол Улсын хөдөлмөрийн баатар
5	2010	Цэвэлмаагийн Баярсайхан	Монгол Улсын Их Хурлын гишүүн, Эдийн засгийн байнгын хорооны дарга
6	2011	Дашдэмбэрэлийн Бат-Эрдэнэ	Монгол Улсын Их Хурлын гишүүн асан
7	2012	Далайн Хамар	Монгол Улсын хөдөлмөрийн баатар
8	2013	Ролжинжавын Батаа	Төр, нийгмийн ахмад зүтгэлтэн
9	2014	Цэенгийн Цэрэндорж	Монгол улсын Соёлын гавьяат зүтгэлтэн, төрийн хан хуурч ерөөлч магтаалч
10	2015	Цэрэвсамба Даваацэрэн	Монгол Улсын Аж үйлдвэрийн гавьяат ажилтан



АЙМГИЙН “ХҮНДЭТ ТЭМДЭГ”-ЭЭР ШАГНАГДСАН ХҮМҮҮСИЙН НЭРС

Он	№	Овог Нэр	Эрхэлдэг ажил
2012	1	Бадамгарав Бадраа	Аймгийн Засаг дарга
	2	Сугир Отгончулуун	“Гүний-ус” ХХК-ний ерөнхий менежер
	3	Бодь Мятав	Галмөнх ХХК-ний захирал
	4	Адъяа Үрчээ	Аймгийн ИТХ даргаар
	5	Дамба Даргахүү	Аймгийн ИТХ даргаар
	6	Сумаа Эрдэнэбат	Аймгийн ИТХ даргаар
	7	Содномцэрэн Цэрэнбаяр	Аймгийн ИТХ даргаар
	8	Бүдээ Чүлтэм	Олон жил удирдах ажил
	9	Мангалжав Равдандорж	Сумын ИТХТөлөөлөгч
	10	Бадамдорж Тогооч	БИНХ-ын дарга олон жил
	11	Авир Идэрцог	ИТХТ, тэргүүлэгч
	12	Муухүү Ядмаа	Олон жил удирдах ажил
	13	Хүү Түмэнбаяр	“Тавантолгой” ХК-ийн гүйцэтгэх захирал
	14	Өөдөс Мөнхтайван	Алдарт уяач
	15	Лхачин Батчулуун	Аймгийн ИТХ-ын дарга
	16	Дамдин Маам	Өндөр настан /барилгын инженер/
	17	Хоохор Бадамсүрэн	УИХ-ын гишүүн асан
2013	1	Соном Рэнчинхорлоо	Ханхонгор сумын ахмад багш
	2	Банди Батбаяр	Манлай сумын Жаргалант багийн малчин
	3	Лувсанбалдан Пунсанцогвоо	Цогт-Овоо сумын ЗДТГ-ын мал эмнэлэг, үржлийн тасгийн дарга
	4	Оюунбат Батчимэг	Аймгийн ИТХТ-ийн ажлын албаны ажилтан
	5	Өөдөс Мөнхтайван	Алдарт уяач
	6	Төмөрхуяг Ганболд	Уяач
	7	Охинбаатар Батмөнх	Гурвантэс сумын Гоёот багийн Засаг дарга
	8	Базар Цоодол	0167-р ангийн дэд хурандаа
	9	Галдандорж Буджаргал	Номгон сумын уугуул, барилгын инженер
	10	Данзанням Даваахүү	Монгол улсын Хөдөлмөрийн баатар, Гавьяат малчин, Тод манлай уяач
2014	1	Чимэддамба Чинжаргал	Баян-Овоо сумын ЗДТГ-ын дарга
	2	Лхагва Төмөртогтох	Гурвантэс сумын “Хөгшөө” ОНӨААТҮГ-ын дарга
	3	Дэчиндорж Цэцэгсайхан	Ханхонгор сумын Элка ХХК-ний захирал
	4	Цэрэн Батсүх	Хүрмэн сумын харьяат
	5	Цэе Наранцэцэг	Цогтцэций сумын малчин
	6	Шар Аюуш	Урлагийн гавьяат зүтгэлтэн
	7	Норов Алтанхуяг	МУ-ын Ерөнхий сайд
	8	Амаржаргал Гансүх	МУ-ын Зам тээврийн сайд
	9	Дэжид Түвдэндорж	Ахмад багш
	10	Чанарав Мөнхжаргал	Аймгийн ГХБХБГ-ын дарга
	11	Бямба Сугир	Гүний ус ХХК-ний орлогын байцаагч
	12	Бат-Өлзий Болормаа	Гүний ус ХХК-ний усан санч
2015	1	Чанцалдулам Цоодол	Эрдмийн гэгээ сургуулийн багш
	2	Бямба Батбаяр	Цогт-Овоо сумын Бортээг багийн ИНХ-ын дарга
	3	Должид Басхүү	Шагай харваач
	4	Жамъянсүрэн Хурцэцэг	Авто тээврийн салбарын ахмад ажилтан



Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын дэргэдэх Иргэний Танхимын
2013 онд зохион байгуулсан хэлэлцүүлгийн үр дүнгийн талаарх мэдээ

№	Хэлэлцүүлгийн сэдэв	Оролцсон хүмүүсийн тоо					Гарсан саналын тоо	Иргэдийн гаргасан саналын дагуу ГАРСАН ТОГТООЛ, ШИЙДВЭР
		Иргэн	ИНБ	Төрийн байгууллага	Хэвлэл мэдээллийн байгууллага	Нийт		
Санал хүсэлт хүлээн авах, судалгааны чиглэлээр								
1	Иргэд, иргэний нийгмийн байгууллага, олон нийтийн бусад байгууллагаас Иргэний танхимын үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгах санал авч боловсруулах	150	20	25	4	199	740	Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2013 оны 49 тоот “Төлөвлөгөө батлах тухай” тогтоол батлагдан 100 хувь хэрэгжсэн.
Иргэд, олон нийтийн саналыг сонсохоор Хэлэлцүүлэг зохион байгуулсан чиглэлээр								
№	Хэлэлцүүлгийн сэдэв	Оролцсон хүмүүсийн тоо					Гарсан саналын тоо	Иргэдийн гаргасан саналын дагуу ГАРСАН ТОГТООЛ ШИЙДВЭР
		Иргэн	ИНБ	Төрийн байгууллага	Хэвлэл мэдээллийн байгууллага	Нийт		
2	“Боловсролын салбарт хийх шинэчлэл” сэдэвт хэлэлцүүлэг	95	6	15	4	120	45	2013 онд Боловсролын салбарт хийх үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөгөөнд иргэдээс гарсан саналын 58.3 хувийг тусган хэрэгжүүлсэн.
3	“Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөнд санал авах нь” сэдэвт хэлэлцүүлэг	11	5	13	6	35	13	Авлигын эсрэг төлөвлөгөөнд иргэдийн гарсан саналыг тусган хэрэгжүүлсэн.
4	“Иргэдээ сонсьё-шийдье” сэдэвт хэлэлцүүлэг	50	10	18	1	79	20	Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 23 тоот “Төлөвлөгөө батлах тухай” тогтоол батлагдан 100 хувь хэрэгжсэн.



5	“Усны үнэ цэнэ” сэдэвт хэлэлцүүлэг	21	5	7	1	35	24	Аймгийн усны ашиглалт хамгаалалт, Дэлхийн усны өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын төлөвлөгөөнд иргэдийн саналыг тусгав.
6	“Эрүүл мэндийн салбарын үйлчилгээг шинэчлэх нь” сэдэвт хэлэлцүүлэг	1389	26	557	6	1978	76	Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2013.06.12-ны өдрийн 53 дугаар тогтоолоор Аймгийн Эрүүл мэндийн шинэчлэл хөтөлбөр батлагдан хэрэгжиж байна.
7	“Хотын дүрэм” боловсруулахад санал авах нь” сэдэвт хэлэлцүүлэг	45	3	30	2	80	17	Дүрэм боловсруулах бүрэлдэхүүнд мэргэжил бүрийн хүмүүс хамруулан боловсруулах санал гаргасны дагуу шийдэгдсэн.
8	“Газар өмчлөлийн өнөөгийн байдал цаашдын төлөвлөлт” сэдэвт хэлэлцүүлэг	32	11	15	2	60	45	Аймгийн ИТХ-ын хуралдааны 3/7 тоот тогтоолоор “Газар өмчлүүлэх ажлыг эрчимжүүлэх ажлын төлөвлөгөө”-нд иргэдийн саналыг тусган батлуулав.
9	“Хүүхэд залуучуудын хүмүүжлийг төлөвшүүлэх арга зам” сэдэвт хэлэлцүүлэг	1076	9	35	2	1150	33	Иргэдийн гаргасан саналыг тусгасан Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2013.10.24-ний өдрийн 109 тоот “Хүүхэд залуучуудын хүмүүжил төлөвшлийг сайжруулах талаар авах арга хэмжээний тухай” 7 заалт бүхий тогтоол гарч хэрэгжиж байна.
10	“Хүнс, хоол тэжээлийн чанар, аюулгүй байдал ба бараа бүтээгдэхүүний үнийг бууруулах боломж” сэдэвт хэлэлцүүлэг	33	16	5	1	55	18	“Хүнсний бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлыг бүрэн ханган ажиллаж байгаа байгууллага, аж ахуй нэгжийг шалгаруулан дэмжих журам” гаргах болон стандартын шаардлага хангасан мах нядалгааны цех байгуулах аймгийн ИТХТ-ийн 2013.10.24-ний 110, 111 тоот Тогтоолууд батлагдлаа.



11	“Монгол хүний үнэ цэнэ ба ажлын байр нэмэгдүүлэх, ажилгүйдлийг бууруулах нь” сэдэвт хэлэлцүүлэг	19	4	4	1	28	10	Иргэдээс гарсан саналыг хэрэгжүүлж ажиллахыг ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 22 тоот “Чиглэл хүргүүлэх тухай” тогтоол батлагдан 100 хувьтай хэрэгжив.
12	“Байгаль орчны нөхөн сэргээлт түүнд хяналт тавих нь” сэдэвт хэлэлцүүлэг	384	16	86	4	490	90	2014 оны аймгийн эдийн засаг, нийгмийн үндсэн чиглэлд иргэдээс гарсан саналыг хэрэгжүүлэхээр холбогдох төсөв нь сууж хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.
13	“Төрийн үйлчилгээний ил тод байдал, хариуцлагыг сайжруулах нь” сэдэвт хэлэлцүүлэг	521	16	45	4	586	195	Иргэдээс гарсан саналыг хэрэгжүүлж ажиллахыг ИТХ-аас аймгийн Засаг даргын Тамгын газарт 4 заалт бүхий Чиглэл хүргүүлсэн тогтоол батлан хүргүүлэв.
14	“Төмөр замын төслийн нийгмийн болон байгаль орчны судалгааны дүнд санал авах нь” нь сэдэвт нээлттэй хэлэлцүүлэг	21	-	11	2	34	26	Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ажлын хэсэг байгуулагдан ажиллаж тайлангаа гаргасан.



Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын дэргэдэх Иргэний Танхимын 2014 онд зохион байгуулсан хэлэлцүүлгийн үр дүн, танхимд зохион байгуулагдсан үйл ажиллагааны талаарх мэдээ

№	Хэлэлцүүлгийн сэдэв	Оролцсон хүмүүсийн тоо					Гарсан саналын тоо	Иргэдийн гаргасан саналын дагуу ГАРСАН ТОГТООЛ ШИЙДВЭР
		Иргэн	ИНБ	Төрийн байгууллага	Хэвлэл мэдээллийн байгууллага	Нийт		
Санал хүсэлт хүлээн авах, судалгааны чиглэлээр								
1	Иргэд, иргэний нийгмийн байгууллагаас Иргэний танхимын үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгах санал авч боловсруулах	80	25	20	2	127	140	Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 23 тоот “Төлөвлөгөө батлах тухай” тогтоол батлагдан 100 хувь хэрэгжсэн.
Иргэд, олон нийтийн саналыг сонсохоор Хэлэлцүүлэг зохион байгуулсан чиглэлээр								
1	“Авлигын эсрэг 2014 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд санал авах нь” сэдэвт хэлэлцүүлэг	78	39	88	2	207	96	Аймгийн Засаг даргын 2014 оны а/41 тоот Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө батлагдан 80 хувьтай хэрэгжсэн.
2	“Өнөөгийн нийгэм дэх боловсролын асуудал” сэдэвт 3 үе шаттай хэлэлцүүлэг	69	19	115	4	209	110	Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 56 тоот “Чиглэл өгөх тухай” тогтоол батлагдан гарч хэрэгжилтийг тооцон ажиллаж байна.
3	“Том төрөөс ухаалаг төр лүү-Ухаалаг төрийн зарчмыг хэрэгжүүлэх нь” сэдэвт хэлэлцүүлэг	1217	45	245	6	1513	559	Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 86,87,88 тоот “Чиглэл өгөх тухай” 4 төрлийн тогтоол батлагдан гарч хэрэгжилтийг тооцон ажиллаж байна.
4	“Тендер, түүний ил тод байдал ба бүтээн байгуулалт барилгын чанар” сэдэвт хэлэлцүүлэг	69	7	32	2	110	78	Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 89 тоот “Чиглэл өгөх тухай” тогтоол батлагдан гарч хэрэгжилтийг тооцон ажиллаж байна.



5	“Даланзадгад хотын зарим хэсгийг дахин төлөвлөлтөд оруулах ба эрүүл хот болоход иргэн бүрийн оролцоо” сэдэвт хэлэлцүүлэг	205	21	56	2	284	210	Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 58 тоот “Чиглэл өгөх тухай” тогтоол батлагдан гарч хэрэгжилтийг тооцон ажиллаж байна. Мөн “Эрүүл хот” хөтөлбөр батлагдан хэрэгжиж байна.
6	“Төсвийн төслийг боловсруулахад иргэдийн оролцоог хангах нь” сэдэвт хэлэлцүүлэг	678	17	132	1	1106	189	Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 14 дүгээр хуралд хэлэлцүүлгийн тайланг танилцуулж 2014 оны 134 тоот “Чиглэл өгөх тухай” тогтоол батлагдан гарч хэрэгжилтийг тооцон ажиллаж байна.
7	Хэлэлцүүлэг							2014.11.21-ны өдөр аймгийн ЗДТГ-ын НХХ-ээс зохион байгуулав.
Сургалтын чиглэлээр								
1	“Иргэний танхим-Иргэдийн оролцоо” сэдэвт сургалт	-	45	25	-	84	-	Төрийн болон төрийн бус байгууллагын ажилтан албан хаагчид хамрагдаж, тодорхой мэдлэг мэдээлэлтэй болсон.
2	“Татварын зөвлөх бэлтгэх” сургалт семинар	-	-	45	-	45	-	Холбогдох мэргэжлийн хүмүүст 2014.09.17-2014.09.20-ны өдрүүдэд зохион байгуулагдаж, мэдээлэлтэй болсон.
4	Газрын харилцааны мэргэжилт-нүүдийн нэгдсэн сургалт	-	-	22	-	22	-	Холбогдох мэргэжлийн хүмүүст 2014.10.07-2014.10.08-ны өдрүүдэд зохион байгуулагдсан.
5	khural.mn цахим сургалт	-	-	15	-	15	-	Өмнөговь аймгийн 15 сумдын ИТХ-ын нарийн бичгийн дарга нарт 2014.10.14-2014.10.15-ны өдрүүдэд зохион байгуулагдсан.
6	Мэргэшсэн нягтлан бодогчийн сургалт	-	-	55	-	55	-	Холбогдох мэргэжлийн хүмүүст 2014.10.23-2014.10.28-ны өдрүүдэд зохион байгуулагдсан.



7	“Даатгалын тухай хуулийн танилцуулга ярилцлага” сэдэвт уулзалт, зөвлөгөөн	26	4	15	2	47	-	Иргэн, аж ахуйн нэгж, жолооч нар, холбогдох мэргэжлийн байгууллагын ажилтан албан хаагчдад 2014.11.05-ны өдөр аймгийн ЗДТГ-ын СТСХ-ээс зохион байгуулав.
8	Статистикийн мэргэжилтнүүдийн сургалт	-	-	40	1	41	-	2014.11.27,28-ны өдөр аймгийн Статистикийн хэлтсээс зохион байгуулав.
9	“Эмэгтэйчүүд манлайлал” сургалт	39	6	15	2	67	-	2014.11.29,30-ны өдөр аймгийн ЗДТГ-ын НХХ-ээс зохион байгуулав.
10	“Хүний эрх” сургалт	28	4	22	1	55	-	2014.12.09-ны өдөр аймгийн ЗДТГ-аас зохион байгуулав.
15	“Залуучуудын ТББ-ын чадавхийг бэхжүүлэх” сургалт	12	31	-	1	44	-	2014.12.10-ны өдөр Иргэний боловсролын төв ТББ, НҮБХАС-ын Залуучуудын хөтөлбөрийг хэрэгжүүлэгч байгууллагаас зохион байгуулав.

Аймгийн Иргэний танхим 2014 онд тодорхой асуудлаар хэлэлцүүлгийг зохион байгуулахдаа иргэдийн оролцоог нэмэгдүүлэх үүднээс төлөвлөсөн хэлэлцүүлгүүдийг үе шаттайгаар зохион байгуулж нийт 6 төрлийн сэдвээр тус бүр 2-3 үе шаттайгаар буюу нийт 13 удаагийн нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулж төр, хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байгууллага, иргэд, олон нийтийн байгууллагын төлөөлөл болох 3429 хүнийг хамруулж, 1242 санал санаачлага гарсныг нэгтгэн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдэд танилцуулан нийт саналын 750 гаруй санал буюу 60 хувийг тодорхой шийдвэрүүдэд тусган хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Иргэний танхимд тодорхой чиглэлээр 10 гаруй төрлийн сургалт зохион байгуулагдлаа.



Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын дэргэдэх Иргэний Танхимын 2015 онд зохион байгуулсан хэлэлцүүлгийн үр дүн, танхимд зохион байгуулагдсан үйл ажиллагааны талаарх мэдээ

№	Хэлэлцүүлгийн сэдэв	Оролцсон хүмүүсийн тоо					Гарсан саналын тоо	Иргэдийн гаргасан саналын дагуу ГАРСАН ТОГТООЛ ШИЙДВЭР
		Иргэн	ИНБ	Төрийн байгууллага	Хэвлэл мэдээллийн байгууллага	Нийт		
Санал хүсэлт хүлээн авах, судалгааны чиглэлээр								
1	Төрийн болон төрийн бус байгууллага, олон нийтийн байгууллагаас Иргэний танхимын үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгах санал авч боловсруулах	-	-	15	-	15	49	Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2015 оны 21 тоот “Төлөвлөгөө батлах тухай” тогтоол батлагдан гарч хэрэгжиж байна.
Иргэд, олон нийтийн саналыг сонсохоор Хэлэлцүүлэг зохион байгуулсан чиглэлээр								
1	“Авлигын эсрэг үйл ажиллагаа, Архигүй Өмнөговь, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ, хөтөлбөр төлөвлөгөөний 2015 оны үйл ажиллагаанд санал авах нь” сэдэвт хэлэлцүүлэг	86	5	36	2	129	96	Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 40 тоот тогтоолын хавсралт, Аймгийн Засаг даргын 2015 оны а/... тоот Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө батлагдан хэрэгжиж байна.
2	“Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих Үндэсний хэлэлцүүлэг” сэдэвт хэлэлцүүлэг	22	58	46	4	130	69	Оролцогчдоос гарсан саалыг нэгтгэн МҮХАУТанхимд хүргүүлэн, ЖДҮ-ийг дэмжих үйл ажиллагаанд тусгуулахар хүргүүлэв.
3	“Иргэдээ сонсоё” сэдэвт хэлэлцүүлэг	151	3	94	1	249	189	Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2015 оны 53 тоот “Усны хэлэлцүүлгийн тухай” тогтоол батлагдан гарч хэрэгжилтийг тооцон ажиллаж байна.



4	“Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх арга зам, цаашид анхаарах асуудал” сэдэвт хэлэлцүүлэг	66	6	62	2	136	187	Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2015 оны 93 тоот “Чиглэл өгөх тухай” тогтоол батлагдан гарч хэрэгжилтийг тооцон ажиллаж байна.
5	“Иргэдийн гэр бүлийн боловсролыг дээшлүүлж, хүүхдийн хүмүүжил төлөвшилд анхааръя” сэдэвт хэлэлцүүлэг	96	2	26	2	126	216	Хэлэлцүүлгийн тайлан, гарсан саналуудыг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдэд танилцуулан холбогдох шийдвэр гаргуулахаар төлөвлөн ажиллаж байна.
6	“Байгаль орчны эсрэг гэмт хэрэг, цаашид анхаарах асуудал” сэдэвт хэлэлцүүлэг	-	-	82	3	85	16	Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2015 оны 136 тоот тогтоол батлагдан гарч хэрэгжилтийг тооцон ажиллаж байна.
7	2016 оны орон нутгийн төсөв, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх арга” сэдэвт хэлэлцүүлэг	45	3	11	2	61	98	2016 онд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх арга хэмжээ батлагдан хэрэгжинэ.
Сургалтын чиглэлээр								
1	“Улсын бүртгэлийн хэлтсийн үйл ажиллагаа, анхаарах асуудал” сургалт /төрийн албан хаагчдад/	-	-	25	1	26	-	Төрийн байгууллагын ажилтан, албан хаагчдад 2015.02.04-ний өдөр зохион байгуулагдсан.
2	Сумдын ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга нарт зориулсан сургалт	-	-	16	1	17	-	Сумдын ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга нарт 2015.02.03-2015.02.04-ний өдрүүдэд зохион байгуулагдсан.
3	“Сурагч-Сургагч багш” сэдэвт байгаль орчны талаарх сургалт	-	29	36	1	66	-	
4	“Арц, Хайлаас тарих аргачлал” сургалт	32	25	29	2	88	-	2015.04.07, 2015.05.08-ны өдрүүдэд зохион байгуулав.
5	“ХАБЭА-н хуулийн шинэчлэл, хэрэгжилт” сургалт	-	-	15	-	15	-	2015.07.16-ны өдөр Хөдөлмөрийн хэлтэс зохион байгуулав.



6	Чанарын удирдлагын тогтолцооны ISO-9001 стандартын сургалт	-	-	179	2	181	-	2015.07.01-2015.07.03-ны өдрүүдэд аймгийн Стандартчилал хэмжилзүйн хэлтсээс зохион байгуулсан.
7	“Зам тээврийн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх нь” сургалт / жолооч нарт/	26	4	15	2	47	-	2015.06.29-ны өдөр аймгийн ЗДТГ-ын ХЗХ,Замын цагдаагийн газраас зохион байгуулав.
8	Байгаль хамгаалах сурагчдын клубын гишүүдэд зориулсан сургалт	-	48	6	-	54	-	2015.06.25-ны өдөр аймгийн Байгаль орчны газар зохион байгуулав.
9	Нийгмийн халамжийн тухай багц хуулийн сургалт /иргэдэд/	36	17	28	-	81	-	2015.06.11-ны өдөр аймгийн Халамж үйлчилгээний газар зохион байгуулав.
10	Сумдын байгаль хамгаалагч нарт чиглэл олгох сургалт	-	-	19	-	19	-	2015.03.03-2015.03.04-ны өдрүүдэд аймгийн Байгаль орчны газар зохион байгуулав.
11	“Өмнөд бүсийн экологийн чухал ач холбогдол бүхий газрыг тусгай хамгаалалтад авах” сургалт	-	10	22	1	33	-	2015.03.05-ны өдөр Байгаль орчны газар зохион байгуулав.
12	“Хөдөлмөрийн аюулгүй байдлын сертификаттай сургалт	-	17	19	1	37	-	2015.03.06-2015.03.10-ны өдрүүдэд аймгийн ГХБХБГ газар БХБ-ын яам, Барилгачдын холбоотой хамтран зохион байгуулав.
13	Иргэний нийгмийн байгууллагуудад мониторинг хийх тухай сургалт	-	26	-	-	26	-	2015.03.11-ний өдөр аймгийн Иргэний нийгмийн сүлжээний байгууллага зохион байгуулав.
14	“Төсөв санхүүгийн байдал” сургалт	-	18	26	1	45	-	2015.03.12-2015.03.13-ны өдрүүдэд аймгийн ЗДТГ-ын СТСХ-ээс зохион байгуулав.
15	“Орон нутгийн тогтвортой хөгжлийг хангахад хүний эрхэд суурилсан хандлагыг нэвтрүүлэх нь” сургалт	-	-	32	1	33	-	2015.03.17-2015.03.18-ны өдрүүдэд УУЯам, Азийн сангийн дэмжлэгтэйгээр Хил Хязгааргүй алхам ТББ, ХЗХэлтэс хамтран зохион байгуулав.



16	Барилгын мэргэшсэн инженерийн сургалт	-	-	32	2	34	-	2015.06.08-2015.06.15-ны өдрүүдэд аймгийн ГХБХБГазар зохион байгуулав.
17	Хүн ам орон сууцны завсрын тооллогын сургалт	-	-	87	1	88	-	2015.07.02, 2015.10.19-ны өдрүүдэд Статистикийн хэлтэс зохион байгуулав.
18	Дүйцүүлэн хамгаалах хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээний сургалт	-	-	45	1	46	-	2015.06.30-2015.07.02-ны өдрүүдэд аймгийн Байгаль орчны газарз охион байгуулав.
19	Усны сургалт	-	-	25	2	27	-	2015.07.03-ны өдөр аймгийн Байгаль орчны газарзохион байгуулав.
20	“Бичил уурхайн нөхөн сэргээлтийн аргачлал” сургалт	-	23	26	1	50	-	2015.10.13-2015.10.14-ны өдрүүдэд Азийн сангийн дэмжлэгтэйгээр аймгийн БОИЗ зохион байгуулав.
21	“ЖДҮ-ийн ХАБЭА, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчнөөс урьдчилан сэргийлэх нь” сургалт	-	25	12	1	38	-	2015.10.20-ны өдөр Хөдөлмөрийн хэлтэс зохион байгуулав.
22	“Иргэний оролцоо” сургалт	96	3	45	2	146	-	2015.10.14-ний өдөр Ерөнхийлөгчийн Тамгын газар, аймгийн ИТХ, ЗДТГ-тай хамтран зохион байгуулав.
Уулзалт зохион байгуулах чиглэлээр								
1	“Мэргэжил сонголт” уулзалт	102	-	16	2	120	-	2015.04.27-ны өдөр аймгийн ЗДТГ-ын НХХ-ээс зохион байгуулав.
2	“Хөдөө аж ахуйн мэргэжил сайхан” сэдэвт уулзалт /ахлах ангийн сурагчдад/	86	-	5	1	92	-	2015.05.30-ны өдөр аймгийн ХХАА-н газар зохион байгуулав.
3	“Байгаль орчны чиглэлийн үйл ажиллагаатай Төрийн бус байгууллагуудын нэгдсэн арга хэмжээ” уулзалт, зөвлөгөөн	-	69	12	-	81	-	МБОИЗ-ийн Өмнөговь аймаг дахь салбар Улирал бүр 2 удаа зохион байгуулав.